БАТЛАВ.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ

БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Т.АРИУНБОЛД

ДУЛААН ХАНГАМЖ, УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ТӨВЛӨРСӨН

СИСТЕМД ХЭРЭГЛЭГЧИЙГ ХОЛБОХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

№ 01

2024 оны 02 сарын 19-ний өдөр.

Барилга обьектын нэр хаяг: Өлзийт сумын ТАХ-ийн албан хэрэгцээний байр

1.Барилга обьектын байршил: Өвөрхангай Өлзийт сум 2-р баг

2.Цэвэр усны тооцоо:

А.Ахуйн ундааны хэрэгцээ: 1,0 м3/хоног

Б.Технологийн хэрэгцээ:

В.Галын зориулалт: 2,5 л/сек

Г.Усалгаа:

Д.Бүгд: 1,0 м3/хоног

3.Цэвэр усны холболт хийх байршилт, өндөржилт, шугамын даралт, диаметр материал

Сумын 240 хүүхдийн сургуулийн ард байрлах гүний худгаас шинээр хийгдэх дулааны сувагт Ф50мм-ийн 67,2 м шугам татаж барилгыг холбоно. Барилгын оруулгын шугаманд стандартын шаардлагад нийцсэн цэвэр усны тоолуурыг бусад тоног төхөөрөмжийн хамт угсарна.Цэвэр усны шугамын материал цайрдсан ган хоолой байна. Стандартын шаардлагад нийцсэн хуванцар хоолойг ашиглаж болно. Барилгад нөөцийн сав угсарч вакум насосоор цэвэр усны хэрэглээг хангана. Иймд техникийн өрөөг нэгдсэн байдлаар тусад нь төлөвлөх шаардлагатай.

4.Усан хангамжийн эх үүсвэр: Тус сумын 240 хүүхдийн сургуулийн ард байрлах ундны усны гүний худгаас цэвэр усаар хангагдана.

5.Дулаан хангамж: Төвлөрсөн усан халаалтын зууханд холбогдоно. 240 хүүхдийн сургуулийн дулааны шугамын төгсгөлөөс ДХ-3 худгаас огтолгоо авч шинээр барих барилгын ачаалалд нийцүүлж шугамын диаметрийг сонгон 67,2 м ган хоолойгоор сувагт дулаалагатай угсран ДХ-4 худгийг шинээр хийнэ. Шинээр баригдах барилгын дулааны үзельд стандартын шаардлагад нийцсэн дулааны тоолуур, бусад тоног төхөөрөмжийг стандартын дагуу суурьлуулна.

Дулааны ачаалал: ..... ккал/ц

6. Дулаан хангамжийн шугамд холболт хийх цэгийн байршилт, өндөржилт, шугамын даралт, диаметр.

Материал ган хоолой, шугамын даралт 4-5 ата. Огтолгоо хийх шугамын диаметр 89 мм, сувагт дулаалагатай угсарсан, худгийн гүн 1,5м.

7.Хэрэглээний халуун усны шугамд холболт хийх цэгийн байршилт, өндөржилт, шугамын даралт, диаметр.

Хэрэглээний халуун усыг барилгад цахилгаан халаагч тавьж шийдвэрлэнэ.

8.Бохир ус: 240 хүүхдийн сургуулийн бага оврын цэвэрлэх байгууламжид холбохоор төлөвлөсөн.

Бохир усны хэмжээ:
A. Ахуйн хэрэгцээнээс гарсан: 1.0 $м^3$/хоног
B. Технологийн хэрэгцээ:
Бүгд 1.0 $м^3$/хоног

9. Бохир усны шугамын холболт хийх цэгийн байршилт, өндөржилт, шугамын диаметр, материал:

Зурагт заасан трассаар ф100мм-ийн хуванцар хоолойгоор (PVC) 6м шугам татаж барилгын анхны худагт холбоно. Хоолойн диаметр 100 мм. Материал хуванцар. Худгийн диаметр 1000 мм. БУХ-1 худгийг шинээр хийнэ. Хөлдөлтийн гүнээс дээр төлөвлөсөн тохиолдолд дулаалах, цахилгаан халаагч кабель тавихаар төлөвлөнө. Барилгын анхны худгаас ф150 мм-ийн хуванцар хоолойгоор 22 м шугам татаж одоо байгаа бага оврын цэвэрлэх байгууламжийн оролтын худагт холбоно.

10.Захиалагч ба зураг төслийн байгууллагууд нь техникийн норм ба стандартыг хатуу баримтлах ба зураг төслийг ус сувгийн байгууллагатай зөвшилцөх шаардлагатай.

11.Ус ханагмж, ариутгах татуургын сүлжээний угаалт, шахалт, туршилт, тохируулгын ажлын зардлыг зураг төсөвт тусгана.

12.Энэхүү техникийн нөхцөл нь олгосон өдрөөс хойш 2 жилийн дотор хүчинтэй. Техникийн нөхцөлийн хугацаа дууссан үед захиалагч байгууллага, ус сувгийн байгууллагад хугацааг сунгуулах буюу дахин шинээр техникийн нөхцөл авах асуудлыг тавина.

13. Барилга угсралтын ажлын явцад зураг төсөлд өөрчлөлт орох шаардлага гарвал ус сувгийн байгууллагаар хянуулж, зураг зохиогчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

14.Техникийн нөхцөлийн нэг хувийг хавсрагдах баримт бичгүүдийн хамт аймаг, хотын засаг даргын тамгын газарт өгнө.

15.Ус сувгийн байгууламжийг барихад газар доорх сүлжээг зөөх, дайрч гарах зам, бут, сөөг эвдэх тохиолдолд сэргээхэд гарах зардлыг төсөвт тусгана.

16.Усны хэмжүүрийн зангилааг үзлэг хийхэд тохиромжтой ус тусгаарлагчтай, гэрэлтүүлэгчтэй,+5°С дээш температуртай өрөөнд байрлуулна.

17.Бусад шаардлагууд: /урьдчилсан цэвэрлэх байгууламж хийх, засварлах, эсвэл одоо байгаа шугам сүлжээг өргөтгөх ба шинээр тавих, үйлдвэрийн газраас гарах бохир усны найрлага гэх мэт/

18. Гүйцэтгэгч нь хангагч байгууллагын хяналтын инженерээр байнга хяналт тавиулж хяналтын карт хөтөлж ажиллана. Дулаан болон бохир усны шугамыг далдлахаас өмнө тусгай зөвшөөрөл бүхий компаниар хэмжилт хийлгэн кадастрын мэдээллийн санд оруулна.

19.Цэвэр бохир усны шугамын шахалт туршилтын үед хяналтын инженерийг заавал биечлэн байлцуулж ил далд ажлын акт хөтөлнө.

20.18,19 дахь заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд барилга ашиглалтанд хүлээн авахгүй.

21.Дараагийн өргөтгөл эхлэх хугацаа, өргөтгөлийн хүчин чадал: одоогоор өргөтгөл хийх төлөвлөлт байхгүй.

22.Уул обьект барих талаар дээд байгууллагын тогтоол шийдвэрийн заалт:

23.Техникийн нөхцөлийг явуулсан газрууд: Өлзийт сумын ЗДТГ, газрын даамал, халаалтын зуух

24.Техникийн нөхцөлтэй холбогдсон схем хавсаргав.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

Аймгийн ГХБХБГазрын БХБХэлтсийн дарга: А.Энхцэцэг

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ. ӨЛЗИЙТ СУМ.

Шинээр баригдах Төрийн албан хаагчдын байрын барилгыг инженерийн шугам сүлжээнд холбох будуурч зураг

2024 он 02-р сар 19 өдөр



Масштаб 1:1000 /1 см-т 10 м багтана/

Таних тэмдэг

- Төрийн албан хаагчдын барилга /төлөвлөж байгаа/
- -- Дулааны шугам /Одоо байгаа/
- -- Цэвэр усны шугам /Одоо байгаа/
- -- Бохирын шугам /одоо байгаа/

Барилга байгуулалтыг тодорхойлогч:

- 1 -Төлөвлөж байгаа Төрийн албан хаагчдын барилга
- 2 -Сумын халуун усны барилга
- 3 -Бохирын цоорог
- 4 -Сургуулийн барилга
- 5 -Нийтийн одолбор газар

Боловсруулсан:

Аймгийн ГХБХБГазрын БХБХэлтсийн дарга /А.Онхцэцэг/

ИЮАЛЗТР